"БЭСТ ФОРТУНА АУДИТ" ХХК

# “УВС ХҮНС”

# ХУВЬЦААТ КОМПАНИ

2023 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР
ДУУСГАВАР БОЛСОН ЖИЛИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

УЛААНБААТАР ХОТ 2024 ОН

"БЭСТ ФОРТУНА АУДИТ" ХХК
Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 2-р хороо
"Урбанек" ХХК-ийн байр 306, 307 тоот
Утас: 324338, 89116465, 98056465, 99095580
И-мэйл: fortune2009audit@gmail.com

2024.03.27 № 59

танай ______________-ны №______________-т

"УВС ХҮНС" ХК-ИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДЭД

## ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

***Зөрчилгүй дүгнэлт***

Бид **"Увс хүнс" ХК**-ийн 2023 оны 12 сарын 31-нээрх Санхүүгийн байдлын тайлан, энэ өдрөөр тасалбар болсон Орлогын дэлгэрэнгүй, Өмчийн өөрчлөлт, Мөнгөн гүйлгээний тайлангууд болон эдгээр тайлантай холбоотой нэмэлт тайлбар тодруулга болон Нягтлан бодох бүртгэлийн бодлогуудад аудит хийж гүйцэтгэлээ.

Бидний дүгнэлтээр Санхүүгийн тайлангуудыг бэлтгэхдээ СТОУС, түүнд нийцүүлэн гаргасан Монгол улсын Сангийн сайдын тушаалаар батлагдсан нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой журам, зааврын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, бодитойгоор илэрхийлсэн байна.

***Дүгнэлтийн үндэслэл***

Аудитын явцад нягтлан бодох бүртгэлийн хувьд баримталсан зарчим, сонгож хэрэглэсэн арга, дотоод хяналтын системийг судлав. Санхүүгийн тайлангууд нь материаллаг алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэл бүхий нотолгоо олж авах зорилгоор аудитын түүврийн болон бусад арга горимуудыг гүйцэтгэсэн бөгөөд бидний гүйцэтгэсэн аудит нь аудитын дүгнэлт гаргахад хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоогоор хангагдсан гэж итгэж байна.

***Санхүүгийн тайлангийн талаар удирдлагын болон засаглал хариуцсан этгээдүүдийн хүлээх үүрэг хариуцлага***

Удирдлага нь Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн дагуу эдгээр санхүүгийн тайланг бэлтгэх, үнэн зөв толилуулах хариуцлага хүлээх бөгөөд мөн залилан юмуу алдаанаас үүдэлтэй материаллаг алдаа зөрчилгүй бэлтгэж, нягтлан бодох бүртгэлийн тохиромжтой бодлогуудыг сонгож хэрэглэх, шударгаар толилуулахтай холбоотой, зайлшгүй чухал гэж өөрийн тодорхойлсон дотоод хяналтуудын талаарх хариуцлагыг хүлээнэ. Засаглал хариуцсан этгээдүүд санхүүгийн тайлагналын үйл явцыг хянах үүрэгтэй.

***Аудиторын хүлээх үүрэг хариуцлага***

Бидний зорилго бол ёс зүйн шаардлагуудыг дагаж мөрдөн, санхүүгийн тайлангууд бүхэлдээ аливаа залилан эсвэл алдаанаас үүдэлтэй материаллаг хэмжээний буруу илэрхийлэлгүй эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах болон бидний дүгнэлтийг багтаасан аудиторын тайлан бэлтгэх юм. Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь өндөр түвшний баталгаажуулалт боловч Аудитын олон улсын стандартын дагуу гүйцэтгэгдсэн аудитаар оршин байгаа материаллаг буруу илэрхийллийг үргэлж илрүүлнэ гэсэн баталгаа өгдөггүй. Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас гарах бөгөөд хэрэв тэдгээр нь дангаараа болон нийлбэр дүнгээрээ санхүүгийн тайлангуудад үндэслэн хэрэглэгчдийн гаргах эдийн засгийн шийдвэрт мэдэгдэхүйц нөлөөлөх бол материаллаг гэж үзнэ.

BEST FORTUNE AUDIT Co.,Ltd
БЭСТ ФОРТУНА АУДИТ ХХК
УЛААНБААТАР ХОТ

**ЗАХИРАЛ Ж. ОЮУНЦЭЦЭГ**

"УВС ХҮНС" ХК

## 2023 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨРХ
## АУДИТЛАГДСАН ТАЙЛАН ТЭНЦЭЛ

(төгрөг)

| Үзүүлэлтүүд | 2023-12-31 | |
|---|---|---|
| | Аудитлагдаагүй | Аудитлагдсан |
| **ХӨРӨНГӨ** | | |
| **Эргэлтийн хөрөнгө** | | |
| Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө | 29,394,058.10 | 29,394,058.10 |
| Дансны авлага | 198,085,746.28 | 198,085,746.28 |
| Татвар, НДШ-ийн авлага | 22,518,404.96 | 22,518,404.96 |
| Бусад авлага | 691,555,489.77 | 691,555,489.77 |
| Бусад санхүүгийн хөрөнгө | - | - |
| Бараа материал | 1,776,400,005.18 | 1,776,400,005.18 |
| Урьдчилж төлсөн зардал/тооцоо | 2,880,000.00 | 2,880,000.00 |
| Бусад эргэлтийн хөрөнгө | | - |
| Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө | - | - |
| ***Эргэлтийн хөрөнгийн дүн*** | ***2,720,833,704.29*** | ***2,720,833,704.29*** |
| **Эргэлтийн бус хөрөнгө** | | |
| Үндсэн хөрөнгө | 1,802,261,910.28 | 1,802,261,910.28 |
| Биет бус хөрөнгө | 219,690,019.60 | 219,690,019.60 |
| Бусад үндсэн хөрөнгө | | - |
| Урт хугацаат хөрөнгө оруулалт | - | - |
| ***Эргэлтийн бус хөрөнгийн дүн*** | ***2,021,951,929.88*** | ***2,021,951,929.88*** |
| **Нийт хөрөнгийн дүн** | **4,742,785,634.17** | **4,742,785,634.17** |
| **ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧИЙН ӨМЧ** | | |
| **Өр төлбөр** | | |
| **Богино хугацаат өр төлбөр** | | |
| Дансны өглөг | 8,320,362.58 | 8,320,362.58 |
| Цалингийн өглөг | 29,328,248.53 | 29,328,248.53 |
| Татварын өглөг | 118,625,072.55 | 118,625,072.55 |
| Хүүгийн өглөг | 2,586,649.89 | 2,586,649.89 |
| Богино хугацаат зээл | 157,526,969.73 | 157,526,969.73 |
| Урьдчилж орсон орлого | - | - |
| Бусад богино хугацаат өр төлбөр | - | - |
| ***Богино хугацаат өр төлбөрийн дүн*** | ***316,387,303.28*** | ***316,387,303.28*** |
| Урт хугацаат зээл | 900,498,868.70 | 900,498,868.70 |
| Бусад урт хугацаат өр төлбөр | - | - |
| ***Урт хугацаат өр төлбөрийн дүн*** | **900,498,868.70** | **900,498,868.70** |
| **Өр төлбөрийн нийт дүн** | **1,216,886,171.98** | **1,216,886,171.98** |
| **Эзэмшигчийн өмч** | - | - |
| Өмч: а) Төрийн | - | |
| б) Хувьцаат | 11,271,600.00 | 11,271,600.00 |
| Халаасны хувьцаа | - | - |
| Нэмж төлөгдсөн капитал | 3,465,126.06 | 3,465,126.06 |
| Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл | 847,420,494.00 | 847,420,494.00 |
| Эздийн өмчийн бусад хэсэг | 179,179,658.00 | 179,179,658.00 |
| Хуримтлагдсан ашиг (алдагдал) | 2,484,562,584.13 | 2,484,562,584.13 |
| ***Эзэмшигчийн өмчийн дүн*** | ***3,525,899,462.19*** | ***3,525,899,462.19*** |
| **Өр төлбөр ба эзэмшигчийн өмчийн дүн** | **4,742,785,634.17** | **4,742,785,634.17** |

БЭСТ ФОРТУНА АУДИТ ХХК 03 сар 27 өдөр

"УВС ХҮНС" ХК

## 2023 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН АУДИТЛАГДСАН ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

(төгрөг)

| Үзүүлэлтүүд | 2023-12-31 | |
|---|---|---|
| | Аудитлагдаагүй | Аудитлагдсан |
| Борлуулалтын орлого | 4,839,198,243.77 | 4,839,198,243.77 |
| Борлуулсан бүтээгдэхүүний өртөг | 2,878,379,301.70 | 2,878,379,301.70 |
| **Нийт ашиг (алдагдал)** | **1,960,818,942.07** | **1,960,818,942.07** |
| Түрээсийн орлого | - | - |
| Хүүгийн орлого | - | - |
| Ноогдол ашгийн орлого | - | - |
| Эрхийн шимтгэлийн орлого | - | - |
| Бусад орлого | | - |
| Борлуулалт маркетингийн зардал | 307,578,405.49 | 307,578,405.49 |
| Ерөнхий ба удирдлагын зардал | 911,686,439.60 | 911,686,439.60 |
| Санхүүгийн зардал | 160,720,710.40 | 160,720,710.40 |
| Бусад зардал | 460,500.00 | 460,500.00 |
| Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз) | 201,414.45 | 201,414.45 |
| Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз) | | - |
| Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз) | - | - |
| Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз) | - | - |
| Бусад ашиг (алдагдал) | | - |
| **Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)** | **580,574,301.03** | **580,574,301.03** |
| Орлогын татварын зардал | 58,083,338.66 | 58,083,338.66 |
| **Татварын дараах ашиг (алдагдал)** | **522,490,962.37** | **522,490,962.37** |
| **Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)** | - | - |
| **Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)** | **522,490,962.37** | **522,490,962.37** |
| **Бусад дэлгэрэнгүй орлого** | - | - |
| Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү | - | - |
| Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | - | - |
| Бусад олз (гарз) | - | - |
| **Орлогын нийт дүн** | **522,490,962.37** | **522,490,962.37** |
| **Нэгж хувьцаанд ноогдох суурь ашиг (алдагдал)** | - | - |

БЭСТ ФОРТУНА АУДИТ ХХК 03 сар 27 өдөр

"УВС ХҮНС" ХК

## 2023 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН АУДИТЛАГДСАН ТАЙЛАН

(төгрөг)

| Үзүүлэлт | Өмч | Халаасны хувьцаа | Нэмж төлөгдсөн капитал | Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл | Эздийн өмчийн бусад хэсэг | Хуримтлагдсан ашиг | Нийт дүн |
|---|---|---|---|---|---|---|---|
| **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **14,736,726.06** | - | - | **847,420,494.00** | | **1,505,021,789.50** | **2,367,179,009.56** |
| Бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | | | | | - |
| Залруулсан үлдэгдэл | 14,736,726.06 | - | - | 847,420,494.00 | - | 1,505,021,789.50 | 2,367,179,009.56 |
| Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал) | - | | | | - | 457,049,832.26 | 457,049,832.26 |
| Бусад дэлгэрэнгүй орлого | - | | | | | - | - |
| Өмчид гарсан өөрчлөлт | - | | - | | - | - | - |
| Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн | - | | - | | | | - |
| **2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **14,736,726.06** | - | - | **847,420,494.00** | - | **1,962,071,621.76** | **2,824,228,841.82** |
| Бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | | | | | - |
| Залруулсан үлдэгдэл | 14,736,726.06 | - | - | 847,420,494.00 | - | 1,962,071,621.76 | 2,824,228,841.82 |
| Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал) | - | - | - | | - | 522,490,962.37 | 522,490,962.37 |
| Бусад дэлгэрэнгүй орлого | - | | | | | - | - |
| Өмчид гарсан өөрчлөлт | (3,465,126.06) | | 3,465,126.06 | | 179,179,658.00 | - | 179,179,658.00 |
| Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн | - | | - | | | - | - |
| **2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **11,271,600.00** | - | **3,465,126.06** | **847,420,494.00** | **179,179,658.00** | **2,484,562,584.13** | **3,525,899,462.19** |

БЭСТ ФОРТУНА АУДИТ ХХК 03 сар 04 өдөр

"УВС ХҮНС" ХК

## 2023 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ЖИЛИЙН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ АУДИТЛАГДСАН ТАЙЛАН

(төгрөг)

| Үзүүлэлтүүд | 2023-12-31 | |
|---|---|---|
| | Аудитлагдаагүй | Аудитлагдсан |
| **Үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ** | | |
| ***Мөнгөн орлогын дүн (+)*** | **5,340,403,461.66** | **5,340,403,461.66** |
| Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого | 5,340,403,461.66 | 5,340,403,461.66 |
| Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого | - | - |
| Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө | - | - |
| ***Мөнгөн зарлагын дүн (-)*** | **5,035,765,017.02** | **5,035,765,017.02** |
| Ажиллагсдад олгосон мөнгө | 618,657,751.26 | 618,657,751.26 |
| Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн | 181,600,000.00 | 181,600,000.00 |
| Бараа, материал худалдан авахад төлсөн | 2,533,870,050.45 | 2,533,870,050.45 |
| Ашиглалтын зардалд төлсөн | 112,890,862.58 | 112,890,862.58 |
| Түлш, шатахуун, тээврийн хөлс сэлбэг хэрэгсэлд төлсөн | 110,941,334.30 | 110,941,334.30 |
| Хүүний төлбөрт төлсөн | 158,134,060.51 | 158,134,060.51 |
| Татварын байгууллагад төлсөн | 907,052,237.53 | 907,052,237.53 |
| Даатгалын төлбөрт төлсөн | 2,097,415.00 | 2,097,415.00 |
| Бусад мөнгөн зарлага | 410,521,305.39 | 410,521,305.39 |
| ***Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ*** | **304,638,444.64** | **304,638,444.64** |
| **Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ** | | - |
| ***Мөнгөн орлогын дүн (+)*** | - | - |
| Үндсэн хөрөнгө борлуулсаны орлого | | |
| Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт | - | - |
| Бусад мөнгөн орлого | - | - |
| ***Мөнгөн зарлагын дүн (-)*** | **216,175,570.00** | **216,175,570.00** |
| Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн | 216,175,570.00 | 216,175,570.00 |
| Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн | - | - |
| Бусдад олгосон зээл болон урьдчилгаа | - | - |
| Бусад мөнгөн зарлага | | - |
| ***Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ*** | **(216,175,570.00)** | **(216,175,570.00)** |
| **Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ** | | - |
| ***Мөнгөн орлогын дүн (+)*** | **500,000,000.00** | **500,000,000.00** |
| Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан | 500,000,000.00 | 500,000,000.00 |
| Валютын ханшийн тэгшитгэлийн ашиг | - | - |
| ***Мөнгөн зарлагын дүн (-)*** | **893,574,196.31** | **893,574,196.31** |
| Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн | 893,574,196.31 | 893,574,196.31 |
| Валютын ханшийн тэгшитгэлийн алдагдал | - | - |
| ***Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ*** | **(393,574,196.31)** | **(393,574,196.31)** |
| **Валютын ханшийн зөрүү** | **201,414.45** | **201,414.45** |
| **Бүх цэвэр мөнгөн гүйлгээ** | **(304,909,907.22)** | **(304,909,907.22)** |
| **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | **334,303,965.32** | **334,303,965.32** |
| **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | **29,394,058.10** | **29,394,058.10** |

БЭСТ ФОРТУНА АУДИТ ХХК 03 сар 24 өдөр

**УВС ХҮНС ХК**

**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД**
2023 ОНЫ 12 САРЫН 31-НЭЭР ДУУСВАР БОЛСОН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

| | |
|---|---|
| ТАЙЛАГНАГЧ ХУУЛИЙН ЭТГЭЭД: | "УВС ХҮНС" ХК |
| ХАЯГ: | Увс аймаг, Улаангом сум, 5-р баг |
| ҮҮСГЭН БАЙГУУЛАГДСАН ОГНОО:<br><br>УЛСЫН БҮРТГЭЛИЙН ДУГААР:<br><br>РЕГИСТРИЙН ДУГААР: | 1942 оны 02 дугаар сарын 18<br>1992-ТӨХорооны шийдвэрээр төрийн өмч давамгайлсан "Чиндмэн" ХК,<br>1999- Бүтэц зохион байгуулалтаа өөрчлөн "Увс хүнс" ХК болсон.<br><br>1510001008<br><br>2001969 |
| ӨМЧИЙН ХЭЛБЭР: | Хувьцаат компани |
| ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ: | ○ 1101 Спирт, архи зэрэг согтууруулах ундаа үйлдвэрлэл<br>○ 1074 Гоймон, пүнтүүз болон энэ төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл<br>○ 0125 Жимс, жимсгэнэ тариалалт<br>○ 4630 Ундаа, цэвэр усны үйлдвэрлэл<br>○ 1071 Талх, талхан бүтээгдэхүүн үйлдвэрлэл<br>○ 1080 Жимс, ногоо боловсруулах, хадгалах |
| ӨӨРИЙН ХӨРӨНГӨ: | 11,271,600.00 төгрөг |
| ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ | ХХААХҮ-ийн сайдын 2010 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн А/152 дугаар тушаалыг үндэслэн "Архины үйлдвэрлэл"-ийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан. |
| ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ: | Л.Нямгэрэлийг 2022 оны 04 дүгээр сарын 13-ны өдрөөс ТУЗ-ийн 22/09 дугаартай тогтоолоор гүйцэтгэх захирлаар томилсон. |
| ЕРӨНХИЙ НЯГТЛАН БОДОГЧ: | Б.Дэлгэрмаа 2020 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн 20/50 дугаар тушаалаар нягтлан бодогчоор томилсон. |

**УВС ХҮНС ХК**

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД
2023 ОНЫ 12 САРЫН 31-НЭЭР ДУУСВАР БОЛСОН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

## САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

*(мянган төгрөгөөр)*

| ҮЗҮҮЛЭЛТ | 2022.12.31 | 2023.12.31 |
|---|---|---|
| **ХӨРӨНГӨ** | | |
| **Эргэлтийн хөрөнгө** | **2,921,556.5** | **2,720,833.7** |
| Мөнгө ба түүнтэй адилтгах өрөнгө | 334,304.0 | 29,394.1 |
| Дансны авлага | 100,723.9 | 198,085.7 |
| Татвар, НДШ-ийн авлага | 2,541.5 | 22,518.4 |
| Бусад авлага | 498,666.6 | 691,555.5 |
| Бараа материал | 1,870,203.3 | 1,776,400.0 |
| Урьдчилж төлсөн зардал | 115,117.3 | 2,880.0 |
| **Эргэлтийн бус хөрөнгө** | **1,846,143.4** | **2,021,951.9** |
| Үндсэн хөрөнгө | 1,777,269.8 | 1,802,261.9 |
| Биет бус хөрөнгө | 68,873.6 | 219,690.0 |
| **НИЙТ ХӨРӨНГӨ** | **4,767,699.9** | **4,742,785.6** |
| **Богино хугацаат өр төлбөр** | **693,471.1** | **316,387.3** |
| Дансны өглөг | 337,522.1 | 8,320.4 |
| Цалингийн өглөг | 32,324.5 | 29,328.2 |
| Татварын өглөг | 197,780.2 | 118,625.1 |
| НДШ-ийн өглөг | - | - |
| Богино хугацаат зээл | 95,735.8 | 157,527.0 |
| Хүүний өглөг | 30,108.5 | 2,586.6 |
| Урьдчилж орсон орлого | - | - |
| Бусад богино хугацаат өр төлбөр | - | - |
| **Урт хугацаат өр төлбөр** | 1,250,000.0 | **900,498.9** |
| Урт хугацаат зээл | 1,250,000.0 | 900,498.9 |
| **Өр төлбөрийн нийт дүн** | **1,943,471.1** | **1,216,886.2** |
| **ЭЗДИЙН ӨМЧ** | | |
| Хувьцаат капитал | 14,736,7 | 11,271.6 |
| Нэмж төлөгдсөн капитал | - | 3,465.1 |
| Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл | 847,420.5 | 847,420.5 |
| Эздийн өмчийн бусад хэсэг | - | 179,179.6 |
| Хуримтлагдсан ашиг | 1,962,071.6 | 2,484,562.6 |
| **ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧИЙН ДҮН** | **2,824,228.8** | **3,525,899.4** |
| **ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН** | **4,767,699.9** | **4,742,785.6** |

*Холбогдох нэмэлт тэмдэглэлүүд нь эдгээр санхүүгийн тайлангуудын салшгүй хэсэг болно.*

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД

2023 ОНЫ 12 САРЫН 31-НЭЭР ДУУСВАР БОЛСОН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

## ОРЛОГО, ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

*(мянган төгрөгөөр)*

| ҮЗҮҮЛЭЛТ | 2022.12.31 | 2023.12.31 |
|---|---|---|
| Борлуулалтын орлого | 4,135,466.7 | 4,839,198.2 |
| Борлуулсан бүтээгдэхүүний өртөг | 2,359,143.4 | 2,878,379.3 |
| **Нийт ашиг** | **1,776,323.3** | **1,960,818.9** |
| Хүүний орлого | - | - |
| Бусад орлого | 2,730.2 | - |
| Борлуулалт маркетингийн зардал | 212,633.9 | 307,578.4 |
| Ерөнхий ба удирдлагын зардал | 927,813.9 | 911,686.4 |
| Бусад зардал | 10,988.1 | 460.5 |
| Гадаад валютын ханшийн зөрүүний олз, (гарз) | 310,0 | 201.4 |
| **Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)** | **508,974.17** | **580,574.3** |
| Орлогын татварын зардал | 51,924.3 | 58,083.3 |
| **ТАЙЛАНТ ҮЕИЙН ЦЭВЭР ҮР ДҮН** | **457,049.8** | **522,491.0** |

*Холбогдох нэмэлт тэмдэглэлүүд нь эдгээр санхүүгийн тайлангуудын салшгүй хэсэг болно.*

## ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

*(мянган төгрөгөөр)*

| ҮЗҮҮЛЭЛТ | Өмч | Нэмж төлөгдсөн капитал | Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл | Эздийн өмчийн бусад хэсэг | Хуримтлагдсан ашиг | Нийт дүн |
|---|---|---|---|---|---|---|
| **2022 оны 01-р сарын 01-ний үлдэгдэл** | **14,736.7** | | **847,420.5** | | **1,505,021.8** | **2,367,179.0** |
| Бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга | | | | | | |
| Залруулсан үлдэгдэл | | | | | | |
| Тайлант үеийн цэвэр үр дүн | | | | | 457,049.8 | 457,049.8 |
| Бусад дэлгэрэнгүй орлого | | | | | | |
| Өмчид гарсан өөрчлөлт | | | | | | |
| Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн | | | | | | |
| **2022 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл** | **14,736.7** | | **847,420.5** | | **1,962,071.6** | **2,824,228.8** |
| Бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга | | | | | | |
| Залруулсан үлдэгдэл | | | | | | |
| Бусад дэлгэрэнгүй орлого | | | | | | |
| Өмчид гарсан өөрчлөлт | (3,465.1) | 3,465.1 | | 179,179.7 | | 179,179.7 |
| Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн | | | | | | |
| Тайлант үеийн цэвэр үр дүн | | | | | 522,491.0 | 522,491.0 |
| **2023 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл** | **11,271.6** | **3,465.1** | **847,420.5** | **179,179.7** | **2,484,562.6** | **3,525,899.5** |

*Холбогдох нэмэлт тэмдэглэлүүд нь эдгээр санхүүгийн тайлангуудын салшгүй хэсэг болно*

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД
2023 ОНЫ 12 САРЫН 31-НЭЭР ДУУСВАР БОЛСОН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

## МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

*(мянган төгрөгөөр*

| ҮЗҮҮЛЭЛТ | 2022.12.31-ний үлдэгдэл | 2023.12.31-ний үлдэгдэл |
|---|---|---|
| **ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **(620,854.7)** | **304,638.5** |
| **Үндсэн үйл ажиллагааны мөнгөн орлого** | **4,519,668.7** | **5,340,403.5** |
| Борлуулалтын орлого | 4,518,440.2 | 5,340,403.5 |
| Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө | 1,228.5 | - |
| **Үндсэн үйл ажиллагааны мөнгөн зарлага** | **5,140,523.4** | **5,035,765.0** |
| Ажиллагсдад олгосон | 573,530.7 | 618,657.8 |
| Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн | 94,374.4 | 181,600.0 |
| Бараа материал худалдан авахад төлсөн | 3,339,069.6 | 2,533,870.0 |
| Ашиглалтын зардалд төлсөн мөнгө | 123,006.4 | 112,890.9 |
| Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн | 122,978.2 | 110,941.3 |
| Бэлтгэн нийлүүлэгчдэд төлсөн бусад мөнгө | 316,810.7 | 410,521.3 |
| Хүүний төлбөрт төлсөн | 94,812.3 | 158,134.1 |
| Татварын байгууллагад төлсөн | 475,941.1 | 907,052.2 |
| Даатгалын төлбөрт төлсөн | - | 2,097.4 |
| **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **(104,831.4)** | **(216,175.6)** |
| Үндсэн хөрөнгө борлуулсаны орлого | | |
| Хүлээн авсан хүүний орлого | - | - |
| Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн | 104,831.4 | 214,375.6 |
| Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн | - | 1,800.0 |
| Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн зарлага | (104,831.4) | (216,175.6) |
| **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **400,000.0** | **(393,574.2)** |
| Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан | 600,000.0 | 500,000.0 |
| Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө | 200,000.0 | 893,574.2 |
| **Валютын ханшийн зөрүү** | **(11.2)** | **201.4** |
| **БҮХ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **(325,697.3)** | **(304,909.9)** |
| **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | **660,001.2** | **334,304.0** |
| **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | **334,304.0** | **29,394.1** |

*Холбогдох нэмэлт тэмдэглэлүүд нь эдгээр санхүүгийн тайлангуудын салшгүй хэсэг болно.*

## АУДИТЫН ДҮГНЭЛТИЙН ТОДРУУЛГА

*2023.12.31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлангийн тухай)*

**"Увс хүнс" ХК**-нь анх 1942 оны 02 дугаар сарын 18-ны өдөр "Идэш тэжээлийн комбинат" нэртэйгээр үйл ажиллагаа явуулж эхэлсэн бөгөөд 1973 оноос Хүнсний комбинат болон өргөжиж, 1992 онд Төрийн өмчийн хорооны шийдвэрээр төрийн өмч давамгайлсан "Чиндмэн" хувьцаат компани болон зохион байгуулагдсан байна. Улмаар 1999 онд бүтэц зохион байгуулалтаа өөрчлөн "Увс хүнс" хувьцаат компани болон өнөөг хүртэл үйл ажиллагаагаа явуулж байна. "Увс хүнс" хувьцаат компани нь нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 112 716 ширхэг энгийн хувьцаанаас бүрдэх дүрмийн сантай, нийт хувьцааны 99.84 хувийг 1 хувьцаа эзэмшигч эзэмшиж байна.

**"Увс хүнс" ХК**-ийн 2023 оны санхүүгийн тайлангуудыг Монгол Улсын Аудитын тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Аудитын Олон Улсын стандарт /АОУС/, Сангийн Яам, Санхүүгийн Зохицуулах хорооны холбогдох журам, шийдвэрүүдийн хүрээнд шалгаж танилцлаа.
Аудитлагдсан санхүүгийн тайлан нь зөвхөн 2023 оны жилийн эцсийн хөрөнгө, санхүүгийн байдал, үйл ажиллагааны үр дүнг тусган үзүүлж байгаа болно.
Байгууллагын удирдлагаас санхүүгийн тайланг тасралтгүй байх зарчимд үндэслэн бэлтгэж, орлого ба зардлыг аккруэль суурьт зарчмаар хүлээн зөвшөөрсөн.
**"Увс хүнс" ХК**-ийн тайлант оны орлого, зарлагын төсөв, үйл ажиллагааны төлөвлөгөөг 2022 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэн баталж, гүйцэтгэлийг тайлагнан ажилласан байна.
Тайлант онд 6,435,812.6 мянган төгрөгийн борлуулалт хийж, 843,889.4 мянган төгрөгийн цэвэр ашигтай ажиллахаар төлөвлөсөн боловч 4,839,198.2 мянган төгрөгийн борлуулалт хийж 522,491.0 мянган төгрөгийн цэвэр ашигтай ажиллан 75.2 хувийн гүйцэтгэлтэй ажиллажээ. Тайлангийн жилд үйлдвэр ямар нэгэн тасалдалгүй хэвийн ажилласан боловч борлуулалт төлөвлөсөн хэмжээнд хүрээгүй нь үйлдвэрийн барааны борлуулалтыг өмнөх оноос хэт өсгөж төлөвлөсөн болон иргэдийн худалдан авах чадвар буурсанаас шалтгаалсан гэж үзэж байна.
**"Увс хүнс" ХК** нь нягтлан бодох бүртгэл хөтөлж санхүүгийн тайлан гаргахдаа Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Компанийн тухай хууль, Сангийн яамнаас гаргасан заавар, журмуудыг баримталж байна.

### 1. Мөнгөн хөрөнгө

Байгууллагын мөнгөн хөрөнгө нь касс дахь бэлэн мөнгө, харилцах данснаас бүрдсэн ба мөнгөн хөрөнгүүдийг валютын төрөл, зориулалт, байршлаар ангилан, нэрлэсэн үнээр үнэлж тэнцэлд тусгасан байна. Бид мөнгөн хөрөнгийн дансуудын тайлант оны гүйлгээ ба үлдэгдлийг аудитын түүврийн ба тулган баталгаажуулалтын аргаар тестлэн шалгаж дараах мэдээллийг олж тогтоов. Үүнд:

**а) Касс дахь бэлэн мөнгө**

*(мянган төгрөгөөр)*

| Төрөл | Валют | 2022.12.31 | 2023.12.31 | Өөрчлөлт |
|---|---|---|---|---|
| Бэлэн мөнгө | төгрөг | 7,814.2 | 605.1 | (7,209.1) |
| Бэлэн мөнгө | рубль | 72.8 | 6,443.5 | 6,370.7 |
| | | 1.5 | 171.0 | 139.5 |
| **Бэлэн мөнгөний дүн** | | **7,887.0** | **7,048.6** | **(838.4)** |

**b) Банкин дахь харилцах данс**

*(мянган төгрөгөөр)*

| Д/д | Харилцагч банк | Валют | Дансны дугаар | 2022.12.31 | 2023.12.31 | Өөрчлөлт |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Төрийн банк | ₮ | 162000888885 | 338.3 | 112.8 | (225.5) |
| 2 | ХААН банк | ₮ | 5822193252 | 320,482.2 | 8,715.2 | (311,767.0) |
| 3 | Худалдаа хөгжлийн банк | ₮ | 499104921 | 125.9 | 125.9 | - |
| 4 | Голомт банк | ₮ | 6200000529 | 1,038.1 | 171.1 | (867.0) |
| 5 | Хас банк | ₮ | 5000499620 | 18.3 | 113.0 | 94.7 |
| 6 | Хас банк | ₮ | 5004497454 | 847.7 | 9,392.5 | 8,544.8 |
| 7 | Хас банк | $ | 5005393737 | 154.7 | 219.7 | 65.0 |
| | | | | 44.91 | 64.41 | 19.5 |
| 8 | Төрийн банк | $ | 240305830309 | 68.0 | 43.6 | (24.4) |
| | | | | 19.73 | 12.79 | (6.94) |
| 9 | Төрийн банк | Руб | 240309932703 | 497.1 | 361.0 | (136.1) |
| | | | | 10,176.18 | 9,581.92 | 594.26 |
| 10 | Худалдаа хөгжлийн банк | $ | 499130735 | 2,732.7 | 2,705.8 | (26.9) |
| | | | | 793.54 | 793.54 | - |
| 11 | Хас банк | CNY | 5002910050 | 32.8 | 355.8 | 322.9 |
| | | | | 66.11 | 741.11 | 675.0 |
| 12 | ХААН банк | Руб | 5822353401 | 36.5 | 5.8 | (30.7) |
| | | | | 748.11 | 153.87 | (594.24) |
| 13 | Голомт банк | Руб | 6205125449 | 44.6 | 23.3 | (21.3) |
| | | | | 913.66 | 618.63 | (295.03) |
| **Харилцах дансан дахь мөнгөний дүн** | | | | **326,416.9** | **22,345.5** | **(304,071.4)** |

Тайлант оны эцэст мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 304,071.4 мянган төгрөгөөр буурсан нь 895,574.2 мянган төгрөгийн урт болон богино хугацаат зээл төлсөн болон бусад өр төлбөрүүдийг төлсөн нь нөлөөлжээ.

## 2. Авлага

Авлагыг дансны авлага, ажилчдаас авах авлага, хувь хүнээс авах авлага, борлуулагч, худалдагчийн тооцооны авлага, татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн авлага, татварын авлага, цалингийн урьдчилгаа, холбоотой талаас авах авлага, онцгой татварын авлага гэж ангилан, нэрлэсэн үнээр бүртгэлд тусгасан ба авлагуудын тооцоолол, хүлээн зөвшөөрөлт ба үнэлгээ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, стандарт, заавар аргачлалын зарчимд нийцэж байна. Мэдээллийг ашиглан дараах мэдээллийг бэлтгэв.

*(мянган төгрөгөөр)*

| Д/д | Авлагын ангилал | 2022.12.31 | 2023.12.31 | Өөрчлөлт |
|---|---|---|---|---|
| 1 | Дансны авлага | 100,723.9 | 198,085.7 | 97,361.8 |
| 2 | Ажилчдаас авах авлага | 27,820.2 | 95,475.8 | 67,655.6 |
| 3 | Холбоотой талаас авах авлага | 470,846.4 | 596,079.7 | 125,233.3 |
| 4 | НӨАТ-ын авлага | - | 4,294.6 | 4,294.6 |
| 5 | Онцгой татварын авлага | - | 18,085.7 | 18,085.7 |
| 6 | НДШ-ийн авлага | 2,541.5 | 138.1 | 2,403.4 |
| **Авлагын дүн** | | **601,932.0** | **941,553.7** | **339,621.7** |

Тайлант оны эцэст авлага өмнөх оноос 339,621.7 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь холбоотой талаас авах авлага 125,233.3 мянган төгрөгөөр өссөн, бэлтгэн нийлүүлэгчид төлсөн урьдчилгаа тооцооны 142,546.0 мянган төгрөгийг дансны авлагаар бүртгэсэн нь нөлөөлжээ.

### 3.Урьдчилж төлсөн зардал, тооцоо

*(мянган төгрөгөөр)*

| Үзүүлэлт | 2022.12.31 | 2023.12.31 | Зөрүү |
|---|---|---|---|
| Урьдчилж төлсөн зардал | 2,400.0 | 2,880.0 | 480.0 |
| Урьдчилж төлсөн тооцоо /татан авалт/ | 112,717.3 | 0.0 | (112,717.3) |
| **Урьдчилж төлсөн тооцооны дүн** | **115,117.3** | **2,880.0** | **(112,237.3)** |

Тайлант оны эцэст өмнөх оны татан авалттай холбоотой тооцоог бүрэн хийж дуусгаснаар дансны үлдэгдэл 112,237.3 мянган төгрөгөөр буурчээ.

### 4. Бараа материал

*(мянган төгрөгөөр)*

| Д/д | Бараа материалын төрөл | 2022.12.31 | 2023.12.31 | Өөрчлөлт |
|---|---|---|---|---|
| 1 | Түүхий эд материал | 1,100,909.0 | 998,510.2 | (102,398.8) |
| 2 | Бэлэн бүтээгдэхүүн | 667,369.5 | 661,734.2 | (5,635.3) |
| 3 | Хангамжийн материал | 58,112.1 | 79,078.5 | 20,966.4 |
| 4 | Сэлбэг хэрэгсэл | 43,812.7 | 37,077.1 | (6,735.6) |
| | **Дүн** | **1,870,203.3** | **1776,400.0** | **(93,803.3)** |

Тайлант онд бараа материалын үлдэгдэл өмнөх оноос 93,803.3 мянган төгрөгөөр буурсан байна. Энэ нь үйлдвэрлэлт, борлуулалт өмнөх оноос 703,731.5 мянган төгрөгөөр өссөнтэй холбоотойгоор түүхий эд материалын үлдэгдэл буурсан нь голлон нөлөөлжээ.

### 5. Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгүүдийг түүхэн өртгөөр үнэлж, төрөл ба зориулалтаар нь ангилан нэрийн дансанд бүртгэж ашиглах хугацаанд шулуун шугамын аргаар элэгдүүлэн, дэлгэрэнгүй бүртгэлүүд ба тэнцэлд хөрөнгийн анхны өртөг ба хуримтлагдсан элэгдлийг зэрэгцүүлэн үзүүлсэн байна.

Тайлант онд 247,921.5 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тээврийн хэрэгсэл, тавилга эд хогшил, компьютер техник хэрэгсэл худалдан авч биет хөрөнгөнд, 1,400.0 мянган төгрөгийн SmartAccouning программ-2 модуль, 400.0 мянган төгрөгийн SmartMobile гар утасны программ, 6,286.3 мянган төгрөгийн лиценз ашиглалтын төлбөр худалдан авч, компанийн эзэмшлийн 387,182 м.кв 5 газрыг 179,179.7 мянган төгрөгөөр үнэлэн нийт 187,266.0 мянган төгрөгийн хөрөнгийг биет бус хөрөнгөнд тус тус бүртгэсэн байна.

Тайлангийн жилд нийт 259,379.0 мянган төгрөгийн элэгдэл байгуулж, элэгдлийг зардлын төвүүдээр ангилан бүртгэсэн байна.

Үндсэн хөрөнгийн анхны өртгийн бүртгэлд материаллаг алдаа илрээгүй ба тайлангийн эхний ба эцсийн үлдэгдлүүдийг доор үзүүлэв.

*(мянган төгрөгөөр)*

| Хөрөнгө | Анхны өртөг | | Хуримтлагдсан элэгдэл | | Үлдэгдэл өртөг | |
|---|---|---|---|---|---|---|
| | 2022.12.31 | 2023.12.31 | 2022.12.31 | 2023.12.31 | 2022.12.31 | 2023.12.31 |
| Үндсэн хөрөнгө | 3,713,541.5 | 3,961,463.0 | 1,936,271.7 | 2,159,201.1 | 1,777,269.8 | 1,802,261.9 |
| Биет бус хөрөнгө | 84,681.8 | 271,947.8 | 15,808.2 | 52,257.8 | 68,873.6 | 219,690.0 |
| **ДҮН** | **3,798,223.3** | **4,233,410.8** | **1,952,079.9** | **2,211,458.9** | **1,846,143.4** | **2,021,951.9** |

## 5. Өр төлбөр

Өр төлбөрийг нэрлэсэн үнэ цэнээр үнэлж, харилцагч байгууллага, хуулийн этгээд бүрээр данс нээж хөтлөн тайлангийн эхний ба эцсийн өдрөөрх өр төлбөрийг дараах дүнгээр илэрхийлж анхан шатны болон хураангуй бүртгэлүүдэд тусгасан байна. Үүнд:

*(мянган төгрөгөөр)*

| Төрлүүд | 2022.12.31 | 2023.12.31 | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Дансны өглөг | 337,522.10 | 8,320.40 | (329,201.7) |
| Цалингийн өглөг | 32,324.50 | 29,328.20 | (2,996.3) |
| ААНОАТ-ын өглөг | 51,924.30 | 37,145.10 | (14,779.2) |
| ХХОАТ-ын өглөг | 29,323.10 | 15,737.70 | (13,585.4) |
| НӨАТ-ын өглөг | 58,124.40 | 24,852.70 | (33,271.7) |
| Онцгой татварын өглөг | 58,137.10 | 40,797.80 | (17,339.3) |
| Бусад татварын өглөг | 271.3 | 91.7 | (179.6) |
| Богино хугацаат зээл | 95,735.80 | 157,527.00 | 61,791.2 |
| Хүүний өглөг | 30,108.50 | 2,586.60 | (27,521.9) |
| Урт хугацаат зээл | 1,250,000.00 | 900,498.90 | (349,501.1) |
| **Өр төлбөрийн дүн** | **1,943,471.10** | **1,216,886.1** | **(726,585.0)** |

Өр төлбөрийн бүртгэл, үлдэгдлийн тооцоолол материаллаг алдаагүй гэж үзэж байна. Тайлант хугацаанд урт хугацаат зээл, татварын өглөг, харилцагч байгууллагад төлөх өглөгүүдийг төлж барагдуулсанаар өглөгийн үлдэгдэл нийт дүнгээрээ 726,585.0 мянган төгрөгөөр буурсан байна.

## 6. Эзэмшигчийн өмч

*(мянган төгрөгөөр)*

| Д/д | Өмчийн төрөл | 2022.12.31 | 2023.12.31 | Өөрчлөлт |
|---|---|---|---|---|
| 1 | Хувьцаат капитал | 14,736.7 | 11,271.6 | (3,465.1) |
| 2 | Нэмж төлөгдсөн капитал | | 3,465.1 | 3,465.1 |
| 3 | Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл | 847,420.5 | 847,420.5 | - |
| 4 | Эздийн өмчийн бусад хэсэг | | 179,179.7 | 179,179.7 |
| 5 | Хуримтлагдсан ашиг | 1,962,071.6 | 2,484,562.6 | 522,491.0 |
| | **Дүн** | **2,824,228.8** | **3,525,899.5** | **701,670.7** |

Тайланд онд эзэмшигчийн өмчийн дүн 701,670.7 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь өмнөх аудитын зөвлөмжийн дагуу газрыг үнэлэн эздийн өмчийн бусад хэсэгт бүртгэсэн болон тайлант оны хуримтлагдсан ашиг нэмэгдсэнтэй холбоотой байна. Мөн өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмж, компанийн дүрэм, Монголын хөрөнгийн биржийн бүртгэлийн дагуу 112716 ширхэг хувьцааны нэрлэсэн үнээр хувьцаат капиталын дүнг 11,271.6 мянган төгрөг болгон залруулж, зөрүүг нэмж төлөгдсөн капитал дансанд бүртгэсэн байна.

## 7. Орлого, үр дүн

*(мянган төгрөгөөр)*

| Үзүүлэлт | 2022.12.31 | 2023.12.31 | Зөрүү |
|---|---|---|---|
| Борлуулалтын орлого | 4,135,466.7 | 4,839,198.2 | 703,731.5 |
| Бусад орлого | 2,730.2 | - | (2,730.2) |
| **Үйл ажиллагааны орлогын дүн** | **4,138,196.9** | **4,839,198.2** | **701,001.3** |
| Борлуулсан бүтээгдэхүүний өртөг | 2,359,143.40 | 2,878,379.3 | 519,235.9 |
| Борлуулалт, маркетингийн зардал | 212,633.90 | 307,578.4 | 94,944.5 |
| Ерөнхий ба удирдлагын зардал | 927,813.90 | 911,686.4 | (16,127.5) |
| **Үйл ажиллагааны зардлын дүн** | **3,499,591.2** | **4,097,644.1** | **598,052.9** |
| **Тайлант үеийн цэвэр үр дүн** | **638,605.7** | **741,554.1** | **102,948.4** |

Өмнөх оноос орлого 701,001.3 мянган төгрөгөөр буюу 16.9 хувиар, үйл ажиллагааны зардал 598,052.9 мянган төгрөгөөр буюу 17.1 хувиар, үүний дотор борлуулсан бүтээгдэхүүний өртөг 22.0 хувиар, борлуулалт маркетинг, ерөнхий удирдлагын зардал 6.9 хувиар тус тус өссөн ба 522,491.0 мянган төгрөгийн ашигтай ажилласныг санхүүгийн тайланд тусгасан байна.

Аудитын сонголтот түүвэр ба бусад аргаар гүйцэтгэсэн сорилын үр дүнг үндэслэн байгууллагын үр дүнгийн тайлангаар тодорхойлогдсон орлого, зарлага, үр дүн нь материаллаг алдаа агуулаагүй гэж үзэж байна.

## 8. Ерөнхий ба удирдлага, борлуулалт маркетингийн зардал

*(мянган төгрөгөөр)*

| | ҮЗҮҮЛЭЛТ | Ерөнхий ба удирдлагын зардал | | Борлуулалт, маркетингийн зардал | |
|---|---|---|---|---|---|
| | | 2022.12.31 | 2023.12.31 | 2022.12.31 | 2023.12.31 |
| 1 | Үндсэн болон нэмэгдэл цалин | 410,760.4 | 454,719.2 | 113,643.8 | 164,174.5 |
| 2 | Нийгмийн даатгалын шимтгэл | 44,599.6 | 56,272.0 | 13,819.0 | 19,442.9 |
| 3 | Албан татвар, төлбөр, хураамжийн зардал | 1,875.1 | 15,425.5 | - | 9.5 |
| 4 | Албан томилолтын зардал | 6,244.0 | 7,525.3 | 731.0 | 410.0 |
| 5 | Мэргэжлийн үйлчилгээний зардал | 17,388.5 | 34,433.2 | - | - |
| 6 | Сургалтын зардал | 1,078.2 | 8,256.4 | - | 180.0 |
| 7 | Элэгдлийн зардал | 211,872.0 | 134,129.9 | - | 17,311.6 |
| 8 | Түрээсийн зардал | 9,829.1 | 4,549.1 | 4,980.0 | 21,600.0 |
| 9 | Ашиглалтын зардал | 23,258.4 | 20,062.3 | 6,408.6 | 15,952.6 |
| 10 | Цэвэрлэгээ үйлчилгээний зардал | 12,130.5 | 4,390.8 | 3,376.0 | 610.7 |
| 11 | Засвар үйлчилгээний зардал | 91,839.1 | 66,381.9 | 23,645.9 | 5,648.5 |
| 12 | Бичиг хэргийн зардал | 3,665.5 | 2,336.1 | 3,084.8 | 2,369.9 |

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД

2023 ОНЫ 12 САРЫН 31-НЭЭР ДУУСВАР БОЛСОН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 13 | Шуудан холбооны зардал | 6,615.8 | 5,777.3 | 537.0 | 1,488.4 |
| 14 | Шатахууны зардал | 21,975.2 | 27,360.4 | 24,453.0 | 25,061.1 |
| 15 | Зээлийн хүүгийн зардал | - | - | - | - |
| 16 | Зар сурталчилгааны зардал | 1,487.0 | 1,271.9 | 1,620.2 | 8,534.9 |
| 17 | Тээврийн зардал | 731.8 | 2,791.7 | 45.0 | 115.0 |
| 18 | Хөдөлмөр хамгааллын зардал | 2,288.8 | 12,065.2 | - | 1,571.3 |
| 19 | Бусад зардал | 60,174.9 | 53,938.2 | 16,289.6 | 23,097.5 |
| | **Үйл ажиллагааны зардлын дүн** | **927,813.9** | **911,686.4** | **212,633.9** | **307,578.4** |

Тайлант онд өмнөх оны аудитын зөвлөмжийн дагуу үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлыг борлуулсан бүтээгдэхүүний өртөгт хуваарилан тооцсон ба удирдлага, борлуулалт маркетингийн зардал нийт дүнгээрээ 78,817.0 мянган төгрөгөөр өссөн байна. Энэ нь цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал өссөнтэй холбоотой байна.

Аудитын явцад хамтран ажилласан ажилтнуудад талархал илэрхийлье.

## АУДИТОРЫН ЗӨВЛӨМЖ

**"Увс хүнс" ХК**-ийн 2023 оны санхүүгийн тайлангийн аудит хийж энэхүү санал зөвлөмжийг хүргүүлж байна.

### 1. Мөнгөн хөрөнгө

*Аудиторын ажиглалт:*
а) Худалдаа хөгжлийн банкин дахь төгрөгийн болон ам.долларын харилцах дансны банкны үйлчилгээний шимтгэлийн гүйлгээг бүртгэлд тусгаагүйгээс эхний болон эцсийн үлдэгдэл зөрүүтэй тайлагнагдсан,

b) Касс дахь бэлэн рублийг тоолж баталгаажуулсан боловч тооллогын дүнгээр дансны үлдэгдлийг тохируулаагүй.

*Аудиторын зөвлөмж:*
Мөнгөн хөрөнгийн гүйлгээг нягтлан бодох бүртгэлд бүрэн тусгаж байх

### 2. Авлага

*Аудиторын ажиглалт:*
а) Тайлант онд 60,438.8 мянган төгрөгийн авлагыг тооцоо нийлж үлдэгдлийг баталгаажуулаагүй, 1 харилцагчийн 11,000.0 сая төгрөгийн авлагыг барагдуулах талаар тодорхой арга хэмжээ аваагүй,

б) Бэлтгэн нийлүүлэгчид төлсөн урьдчилгаа тооцооны 142,546.0 мянган төгрөгийг дансны авлагаар бүртгэсэн.

*Аудиторын зөвлөмж:*
а) Жилийн эцэст харилцагч байгууллагуудын үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулж байх, олон жил болсон авлагыг барагдуулах талаар хууль хяналтын байгууллагатай хамтран ажиллах,

б) Дансны авлага, урьдчилж төлсөн тооцооны авлагыг зөв ангилан бүртгэж байх.

### 3. Хөрөнгийн бүртгэл

*Аудиторын ажиглалт:*
а) Программын лиценз ашиглалтын төлбөрийг патентаар бүртгэж хорогдуулалтыг хийсэн,

б) 34,681.8 мянган төгрөгийн өртөгтэй борлуулалт, санхүүгийн цогц Смарт программын ашиглалтын хугацааг 2 жилээр тооцон хорогдуулалтыг өндөр дүнгээр тайлагнасан.

*Аудиторын зөвлөмж:*
а) Программын лиценз ашиглалтын төлбөрийн дүнгээр хөрөнгийн анхны өртгийг капиталжуулах,

б) Биет бус хөрөнгийн ашиглалтын хугацааг зөв тодорхойлж, хорогдуулалтыг тооцон нягтлан бодох бүртгэлд тусгах.

**4. Хөрөнгийн тооллоготой холбоотой**

*Аудиторын ажиглалт:*

2023 оны жилийн эцсийн бараа материал, үндсэн хөрөнгийн тооллого хийж, тооцоог бодоогүй, тооллого явуулах тушаал шийдвэр гаргаагүй.

*Аудиторын зөвлөмж:*

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2.Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ, 12.2.1.жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө; заалтыг хэрэгжүүлж ажиллах.

**ЗӨВЛӨМЖ ӨГСӨН:**

"БЭСТ ФОРТУНА АУДИТ" ХХК-ИЙН ЗАХИРАЛ Ж.ОЮУНЦЭЦЭГ

АХЛАХ АУДИТОР Б.НАРАНГЭРЭЛ